



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 198

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа,
үнийг шинэчлэн тогтоож, балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 5.6, 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 2,784,278.40 (хоёр сая долоон зуун наян дөрвөн мянга хоёр зуун далан найман төгрөг дөчин мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий Хьюндай Старекс маркийн, 84-92 УБЦ улсын дугаар, KMJWWHWP6U793400 арлын дугаартай тээврийн хэрэгслийн ашиглах хугацааг 2 жилээр сунгаж, үнийг 1,500,000.00 (нэг сая таван зуун мянга) төгрөгөөр шинэчлэн тогтоож Хил хамгаалах ерөнхий газрын харьяа "Хилийн цэргийн 0288 дугаар анги" төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Хил хамгаалах ерөнхий газрын дарга, хошууч генерал Ж.Лхагвасүрэн, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Х.Эрдэм-Ундрах нарт дор дурдсан арга хэмжээг авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгийн ашиглах хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоох, хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3.Тээврийн хэрэгслийн татвар төлөгчийн бүртгэл, улсын дугаарыг автотээврийн бүртгэлээс шилжүүлж арга хэмжээний биелэлтийг 2024 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх;

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132001374
11-r huraldaan.docx